

ЛАМЫН ГЭГЭЭНИЙ НАМТАР, “ТОДРУУЛАГЧ ЗУЛ” СУДРЫН
АГУУЛГЫГ ШИНЖЛЭХ АСУУДАЛ

М.Шинэгэрэл¹, Б.Сумъяацэрэн², Г.Сумъяахорол³, А.Хулангаа⁴, Ш.Болд⁵

^{1,2,3,4}Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль,

⁵Уламжлалт анагаах ухааны эрдэм судлалын хүрээлэн

THE ISSUE OF CLARIFYING THE CONTENT OF THE
LAMA GEGEEN'S BIOGRAPHY AND THE
“GSAL BA'I SGRON ME” SUTRA

Shinegerel M¹, Sumyatseren B², Sumyakhorol G³, Hulangaa A⁴, Bold Sh⁵

^{1,2,3,4}Mongolian University of Pharmaceutical Sciences

⁵Traditional Medical Research Institute

Abstract

Introduction: The basis of the development of traditional Mongolian medicine in the 21st century is the importance of reading and studying the biographies of previous generations of ancient doctors and scientists, as well as old medical books and sutras. For example, it is important to gain a deeper understanding of the scientific basis of the ancient medical books, and to understand the manuals and treatment's methods of doctors and maarambas.

Research goal: Studying the biography of Erdene Bandida Khutagt, Khamba Nomuun Khan Hanchen Choijal Luvsandanzanjantsan, and his medical book titled “gsal ba'i sgron me”.

Research methods: We used following study methods; manuscripts, primary source methods, hermeneutic method, matrifocal listing method, historical comparative method and analysis synthesis method.

Result: Erdene Bandida Khutagt, Khamba Nomuun Khan Hanchen Choijal Luvsandanzanjantsan, the first incarnation of the Lama Gegeen, was born on the 15th of January 1639, in Ulziit Ovoo, Sain Noyon Khan aimag. In 1643, at the age of five, he was initiated by Namkhaisodnomdagva and named Choijidorj. In 1644, at the age of six, he went to Tibet in order to study Tibetan script, calligraphy, and secret tantric rituals and other subjects including medicine taught by Luvsanyarpel, who came to Mongolia from the Dashlkhumbе Monastery of Tibet. Thus, from an early age, he was immersed in religious and medical teachings. Luvsandanzanjantsan has written five books in Tibetan. We selected the book titled “mkhan chen chos kyi rgyal poi gsung ‘bum las gso ba rig pa'i rtsa rgyud kyi' grel pa gsal ba'i sgron me ces bya ba bzhugs so” as our main subject of study. The book clearly explains the “Root Tantra” of the “Four Medical Tantras”, clarifies the difficult words and content of the theory and makes it easier for people to learn. In addition, we have studied the structure, content, and concluding remarks of this book.

Conclusion: Luvsandanzanjantsan was not only a scientist who penetrated the five great sciences, but also made a valuable contribution to the expansion of Mongolian medical research field and the introduction of Tibetan medicine into Mongolia. He is credited with reviewing and commenting on the best medical works of Indian and Tibetan scholars.

Keywords: traditional. Mongolian medicine, Luvsandanzanjantsan, and sutra

Үндэслэл

1990 оноос уламжлалт анагаах ухаан сэргээгдэн хөгжөөд 30 гаруй жил өнгөрч, уламжлалт анагаах ухаан судлалын хүрээнд олон арван сурах бичиг, бүтээл гарч, мэргэжилтэй боловсон хүн бэлтгэгдэж байгаа хэдий ч уламжлалт эмнэлгийн тусламжийн чанар, эмч нарын мэдлэг, мэргэжлийг эрс дээшлүүлэх шаардлагатай байна. Ингэхийн тулдуламжлалтанагаахухааныоюутнуудадөгч байгаа мэдлэгийг “нотолгоонд тулгуурласан”, уламжлал, шинэчлэлийг оновчтой хослуулсан “ухаан” болгох нь чухал юм⁴. Нэн ялангуяа XXI зууны уламжлалт анагаах ухааны хөгжлийн үндэс нь өмнөх үеийн эмч, эрдэмтдийн намтар, бүтээн туурвисан анагаах ухааны хуучин ном, судрыг уншиж судлах, уг номонд байгаа шинжлэх ухааны үндэстэй ойлголтыг гүнзгийрүүлэн ухаарах, эмч, маарамба нарын гарын авлага, увдисыг гүн утгыг онож ойлгох нь чухал байна.

Зорилго: Эрдэнэбандидахутагт, хамбаномуун хан Ханчэн чойжал Лувсанданзанжанцангийн намтар, анагаах ухааны бүтээлийг тодруулна.

Судалгааны арга

Герменевтик арга: Тайлбарлах тодруулах гэсэн грек үгнээс гаралтай бөгөөд сэдвийн өгүүлэмж, нэр томьёо, үгийн утгын тайлал хийх, тайлбарлах, орчуулахад герменевтик арга зүйг боловсруулсан. Герменевтик нь судалж буй зүйлийнхээ учир зүйг учир шалтгааны холбоогоор тайлбарлан судалдаг.

Анализ-синтезийнарга: Задланшинжлэх, нэгтгэн дүгнэх арга. Анализ нь задлах, ялгаж салгах гэсэн утгатай бөгөөд судлаач сонгож авсан объект буюу ном судрын агуулгыг тодорхой бүрэлдэхүүн хэсгүүдэд ангилна. Ингэснээр тухайн объектын хийсвэрлэж болох үндсэн шинж чанарууд тодорхой бүрэлдэхүүн хэсгүүд дээр илүү тод илэрч гарна. Анализ

хийх нь объектыг задлан шинжилснийг шууд дагалдан зайлшгүй хийгддэг сэтгэхүйн логик үйлдэл юм.

Судалгааны үр дүн

Ламын гэгээний анхдугаар дүр, монгол отчийн оройн дээд чимгийн нэг, их зурхайч, Эрдэнэ бандида хутагт, хамба номуун хан Ханчэн чойжал Лувсанданзанжанцан машид гарсан XI жарны “согтох төгөлдөр” хэмээх шороон эм туулай жилийн (1639 он) хаврын тэргүүн сарын 15-нд Сайн ноён хан аймгийн Өлзийт овоо (одоогийн Өвөрхангай аймгийн Хангай ханы орчим) гэдэг газар мэндэлжээ. Түүний эцэг Лояг эрх чөөхүр нь Чакраварди хаан хэмээн алдаршсан Их богд эзэн Чингис хааны 27 дугаар үе Батмөнх даян хааны 10 дахь хөвгүүн Жалайр хунтайжийн 3 дугаар хүү Нонохуй Үйзэн, түүний 4 дүгээр хүү Түмэнхэн сайн ханы (Хөндлөн чөөхүр ноён) 13 хөвгүүний дөрөвдүгээр хүү юм. Эх нь Чингисийн дүү Хавт Хасарын удмаас гарсан эхнэрийн эрдэм төгссөн, цагаан дарь эхийг үргэлж амны уншлага болгосон нэгэн байжээ. Лувсанданзанжанцан 1643 он (Харагчин хонин жил)-д 5 настайдаа Намхайсодномдагва багшаас “Цогт-очир”, “Сүрдүүлэгч (Ямандаг) 13 бурхан”-ы авшиг хүртэж Чойжидорж хэмээх номын нэр авчээ. 1644 он (Хөх бичин жил)-д 6 настайдаа Төвөдийн Дашлхүмбэ хийдээс Монгол оронд морилон ирсэн цорж Лувсанярпэлээс төвөд хэл бичиг, холбон найруулах ухаан, аахар шаахар уншлага, итгэл, нууц тарнийн зан үйл, охин тэнгэрийн магтаал зэрэг номыг суралцахын хамт насан урт, морь тэргүүтэн 3 язгуурын Гомбо зэргийн даган соёрхлыг хүртсэн ажээ. Ингэж тэрбээр хар багаасаа шашины номын үйлст шимтэн ном эрдэмд ша ргуу байсан байна.

1645 он (Хөхөгчин тахиа жил)-д 7 настайдаа Лувсанярпэл багшаас тойн сахил хүртэн Лувсанданзанжанцан хэмээх сахилын

нэртэй болжээ. Мөн Чойжилпэрэнлэйжамцыг багш барьж “Жаран их билиг”, “Галын түлшний өглөг” (галын тахилга) зэрэг бурхан шашины нууц тарнийн гарын авлага, даган соёрхол мэтийг хүртсэн байна.

1649 он (Шарагчин үхэр жил)-д 11 настайдаа Сэра хийдийн шавь эмч Гунгажанчаваас “Анагаах ухааны язгуурын үндэс” болон “Шинжлэл заслыг тодорхойлсон үндэс”-ийг суралцаж анагаах ухааны онолын мэдлэгийг эхлэн эзэмшсэн бөгөөд тусыг бүтээхэд хэрэгцээ бүхий одон зурхай, монгол хэл бичгийг сайтар сурчээ.

1652 он (Хар луу жил)-д 14 настайдаа “Онолын үндэс”-ийг сурсан байна.

1674 он (Хөх барс жил)-ийн 5 дугаар сарын 13-ны өдөр 36 сүүдэртэйдээ Их хүрээнд хүрэлцэн ирэв. Түүнийг ирэхэд Монголын шар, хар олон түмэн шарын шашины угтлага ёсоор угтан авч 20 гаруй өдөр баяр хөөртэй байсан байна. 6 дугаар сарын 13-ны өдөр тэрбээр Дашлхүмбийн ёсоор чойр болон нууц тарнийн салбарыг байгуулж өгөв. Мөн тэр жилийн өвөл анхдугаар Жавзандамба хутагт Лувсандамбийжанцан (1635-1723 он)-гаас Эрдэнэ бандида хутагт гэсэн цол өргөмжлөгдөв. Үүнээс хойш шарын шашны дүрэм, тогтоолыг орон нутагтаа тохируулан тогтоож, шавь сургаж, эрдэм мэдлэгээ зааж олон эрдэмтнийг төрүүлэв. Мөн эм барьж хүмүүсийн өвчин эмгэгийг засч эдгэрүүлэхийн сацуу шашин номыг хөгжүүлэх монгол соёлыг дэлгэрүүлэх, үндэсний анагаах ухааны салбарыг буй болгох, ном бичиг туурвих мэтийн үйлст хүч чадлаа шавхан дайчилжээ. Тэрбээр төвөд хэлэнд нэвтэрхий бөгөөд анагаах ухаан, зурхай, уран зохиол зэрэг олон зүйлийн салбар ухаануудыг сайн мэддэг болохоор эдгээр шинжлэх ухаануудыг нийтэд нь хамарсан 79 иж, 220 анги зохиол бүтээл туурвин 4 боть болгон эмхэтгэсэнээр

монгол соёлын хөгжилтөнд ихээхэн хувь нэмэр оруулсан байна. Түүний бүрэн зохиолыг Жанжаа хутагт Ролбидорж (1717-1786 он)-оос оршил бичиж Жанжин хошууч чин ван Дэчинжав, Засаг эрх ах Самдүвжав, засаг эрдэнэ дайчин Лхачогжав нар өглөгийн эзэн болж Сайн ноён хан аймагт модон бараар хэвлэснээс гадна бүрэн зохиолын зарим иж зохиолыг нь Буриадын Цүгэл сүмд бард гаргажээ. 1681 онд “Баясгалан үйлдэгч буяныг арвижуулагч сүм”-ийг Бөөрөлжүүт гэдэг газар гэлэн Даваасамбуу ламаар удирдуулан 60 ламтайгаар байгуулж уул хийдийг Ламын гэгээнд өргөжээ. Энэхүү хийд гурван дацантай, дөрвөн цагт Гүнрэг, Аюуш, Минтүг, Манла зэрэг хурал хурдаг байв. 1685 онд Лувсанданзанжанцан 47 сүүдэртэйдээ энэ хийдээ улам өргөжүүлэн Мамба дацан нэмж байгуулжээ.

1701 онд (Цагаагчин могой жил) 63 настайдаа Заяа бандида Лувсанпэрэнлэй (1642-1715 он)-н урилгаар Заяын хүрээнд заларч шинээр б айгуулагдсан сүм хийдэд машид оршсон түлш өглөг мэтийн шашны үйлийг гүйцэтгэж байсан бөгөөд бас анагаах ухааны ном, эм заслын гарын авлагыг заан сургаж, дэлгэрүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийсэн байна. Түүнээс гадна зурхай суралцагчдад зурхай, одон орны судлалыг заах, Монгол оронд одон зурхайг дэлгэрүүлэх их үйлсийг гүйцэтгэжээ⁵.

1704 он (Хөх бичин жил)-д 66 настайдаа таалал төгсчээ.

Лувсанданзанжанцангийн төвөд хэлээр зохиосон олон зүйлийн ухааны зохиол бүтээл 4 боть, 79 иж, 220 анги буй. Эдгээр зохиолоос анагаах ухааны талаар туурвисан 5 зохиол буй.

“Анагаах ухааны язгуур үндсийн тайлбар тодотгогч зул хэмээх оршвой”⁶.

Төвөд хэлээр *མཁམན་ཚེན་ཚོས་ཀྱི་རྒྱལ་པོའི་གསུང་འབྲུག་ལས་གསོ་བ་*
རིག་པའི་རྩ་རྒྱུད་ཀྱི་
འགྲེལ་བ་གསལ་བའི་རྒྱན་མི་ཅེས་བྱ་བ་ *བཞུགས་སོ།* гэдэг. Энэ ном нь язгуур
үндсийн хэсгийг тодорхой тайлбарласан
бэрх үг болон агуулгыг нь онолын талаар

нарийн гаргаж онолыг баяжуулан хүмүүс
сурч эзэмшихэд хялбар болгожээ. Энэ ном
9×50 см хэмжээтэй 41 хуудастай монгол
модон бараар хэвлэгдэж Үндэсний номын
сан, Гандантэгчинлэн хийдийн ном, хувь
хүмүүст хадгалагдаж байна.




Figure 1. Page of Lama Gegeen’s Biography and the
“gsal ba’i sgron me” sutra

Уг судар Цог төгөлдөр дээд оточ багш
өлмийн хаан лугаа ялгалгүй өөрийн багшийн
өлмийд хичээнгүйлэн биширч мөргөмүй
гэж эхэлдэг. Үндэсний дээд рашааны шим
язгуур үндэс Ютог, Сурхарва Лодойжалбуу
тэргүүтэн урьдын мэргэдийн олон тайлбар
тэдгээрээс үлэмж чухал зохиол хаа байх
билээ. Хувь буурай нөхдөдөө туслахын төлөө
төрөл удамдаа авъяас чадалаа үлдээхийн
төлөө “Тайлбар тодруулагч зул” хэмээхийг
багшийнхаа ачаар өчүүхэн номлож үлдээлээ
гэсэн байдаг. Эцэст нь Төгсбурханы хутгийг олж,
маш ариун ном номложээ. Тэдгээр нь гурван
хорын шалтгааны үл мэдэх номлогдохууны
ерөндгийг номлосон тул эмнэлгийн гол шастир
болжээ. Түүнчлэн нисваанисын тачаангуйгаас
хий, уураас шар, мунхагаас бадган үр өвчин
дөрвөн зуун дөрвийн ерөндгийг номлосон цог
төгөлдөр “Дөрвөн үндэс”-ийн шим нь болсон
“Язгуур үндэс” хэмээн алдаршсан номыг
тайлбарлалаа. Ламын гэгээн өгүүлэхдээ
нэгдүгээр бүлгийг аль болохоор өөрийн

мэдсэнээрээ тайлбарлахаар чармайлаа. Гол
шастир хийгээд Ютог, Сурхарвын таалсан
үзлүүд ба уг гарал нь ариун итгэмжтэй
тайлбар “Дээдсийн чухал сургаал”, ялангуяа
миний цог төгөлдөр эрхэм багш, талын наран,
их Арш Лувсанжамцбалсангийн “Нүүрийн
гэгээ номлол”, “Гарын авлага” зэрэг ном
судруудыг сонгон авч тайлбарласан болой.
Мөн сүүлийн бүлгийн үндэс хийгээд хуваарь
сэдвийн барилдлагыг шадарлах ёсоор бичсэн
болохоор билиг буурай хүмүүс “утга” хийгээд
“сэдэв”-ийг андуурч мэднэ. Хэрвээ буруу
тайлбарласан бол билгийн нүд төгөлдөр
мэргэд та бүгд эрс шууд зогсоож, нүдэндээ
түүтгэр үл болгох талаас нь адислан соёрхоно
уу хэмээжээ.

Лувсанданзанжанцан таван ухаанд
нэвтэрсэн эрдэмтнээр барахгүй Монгол
анагаах ухааны эрдэм судлалын ажлыг
өргөжүүлэн улмаар анагаах ухааныг сурч
эзэмшсэн анхны монгол эмч Энэтхэг,
Төвөдийн эрдэмтдийн шилдэг бүтээлүүдэд

дүгнэлт, тайлбар хийсэн хүн гэж үздэг. Эрдэнэ бандида хутагт, хамба номуун хан Ханчэн чойжал Лувсанданзанжанцангийн намтар, бүтээлийг өнөөгийн мэдлэгийн хүрээнд олдсон зарим материалыг түшиглэн тодруулах нь нэг талаас танин мэдэхүйн болон практикийн ач холбогдолтой бөгөөд нөгөө талаас уламжлалт анагаах анагаах ухааныг цаашид хөгжүүлэн дэлгэрүүлэхэд үндсэн суурийн нэгээхэн хэсэг болох юм.

Ном зүй

1. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006, тал 16
2. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. 4 боть, УБ, 2013
3. Монголын уламжлалт анагаах ухааны эм найрлагын судлал. (Төслийн удирдагч академич Ш.Болд, академич Д.Цэрэнсодном) УБ, 2014, х.24
4. Монголын уламжлалт анагаах ухааны эм судлал. Ерөнхий редактор, академич Ш.Болд. УБ, 2014, х.7
5. Болд Ш, Жавхлан Б. Хүннүгээс XXI зууны Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш, бариач нарын цадиг, бүтээлийн ойллого. УБ, 2016
6. Лувсанданзанжанцан.མཁན་ཆེན་ཚོས་གྲི་རྒྱལ་པོ་འཇུག་པའི་འབྲུག་ལས་གསོ་བ་རིག་པའི་རྩ་རྒྱུན་གྱི་འགུལ་བའི་གསལ་བའི་སློན་མེ་ཅེས་བྱ་བ་བཞུགས་སོ། Анагаах ухааны язгуур үндсийн тайлбар тодотгогч зул хэмээх оршвой. Модон барын хэвлэл.

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:

АШУ-ы доктор, профессор

Ч.Чимэдрагчаа